



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 11 сарын 01 өдөр

Дугаар А/7259

Улаанбаатар хот

Нийслэлийн өмчөөс төрийн өмчид
эд хөрөнгө шилжүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.2 дах заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, мөн зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 5 дахь заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 120 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сүхбаатар дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нийт 41,500,000.00 (дөчин нэгэн сая таван зуун мянга) төгрөгийн үнэтэй, үлдэх өртөггүй хавсралтад заасан тээврийн хэрэгслийг нийслэлийн өмчөөс төрийн өмчид шилжүүлсүгэй.

2. Энэ захирамжийн 1-д заасан тээврийн хэрэгслийг төрийн өмчид шилжүүлэх ажлыг зохион байгуулж, данс бүртгэлээсээ хасахыг Сүхбаатар дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын алба (Ц.Осорваань)-нд үүрэг болгосугай.

3. Энэ захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Өмчийн харилцааны газар (В.Оюумаа)-т даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ



Х.НЯМБААТАР

1110205521

Нийслэлийн Засаг даргын 2024 оны
... дугаар сарын ... ны өдрийн
... захирамжийн
хавсралт

НИЙСЛЭЛИЙН ӨМЧӨӨС ТӨРИЙН ӨМЧИД ШИЛЖҮҮЛЭХ
ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ЖАГСААЛТ

№	Эд хөрөнгийн нэр	Марк	Улсын дугаар	Арлын дугаар	Ашиглалтад орсон он	Бүртгэлийн үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэх өртөг	Шилжүүлэх байгууллага	Шилжүүлэн авах байгууллага
1	Тээврийн хэрэгсэл	Киа оптима	04-13 УНУ	KNACN412B C5237364	2012	41,500,000.00	41,500,000.00	-	Сүхбаатар дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал	Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн тамгын газар
Нийт дүн						41,500,000.00	41,500,000.00	-		